Баян сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн.
- Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль /2022 оны 04 дүгээр сарын 2-ний өдөр батлагдсан./
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол,
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай ЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/49 дүгээр тогтоол;
Эмнэлэг, эрүүл мэндийн салбарт хийж байгаа шинэчлэл, үйл ажиллагаа, төсөв санхүүг дэмжсэн шийдвэрийг Засгийн газар, салбарын сайд, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлөөс гаргаж мөрдүүлсэн байна. Үүнд:
 - “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” ЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт”-аар “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээ”-г тогтоосон;
 - “Эмнэлэг, эрүүл мэндийн салбарт 2022 онд Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Цусны донорын тухай, Тамхины тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан ажилласан байна.;

- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр “Журам батлах тухай” тушаал;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай” 06 дугаар тогтоол;
- “Төрөөс эмийн зардлыг нь хариуцан амбулаториор эмчлэх өвчний жагсаалт, эм олгох үйл ажиллагааг зохицуулах журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/407 дугаар тушаал;
- ЭМСайдын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалаар “Төрийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй үйлчилгээний жагсаалтыг баталсан;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 01 дүгээр тогтоол;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 05 дугаар тогтоол;
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний “Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай” 2022 оны 09, 14 дүгээр тогтоол;
- Сангийн сайд, ЭМС-ын 2022 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 49,А/118 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтаар Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаа иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний төлбөрийн жишиг жагсаалтыг, хоёрдугаар хавсралтаар Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журмыг баталсан;
- ЭМС-ын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А/216 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний журам”, хоёрдугаар хавсралтаар “ Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жагсаалт”-ыг тус тус баталсан;
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 09 дүгээр тогтоолын 2-т” Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн үйлчилгээний нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл 20 хувь, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх хэвтүүлэн эмчлэх, яаралтай тусламж, түргэн тусламж, шүд, амны хөндийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 05 болон 06 дугаар сарын статистик тоон мэдээлэл дээр үндэслэн хяналт тавьж санхүүжүүлэх;
- ЭМДҮЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн 14 дүгээр тогтоолын 2-т” Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлсэн үйлчилгээний нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн үлдэгдэл 20 хувь, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх хэвтүүлэн эмчлэх, яаралтай тусламж, түргэн тусламж, шүд, амны хөндийн тусламж үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн байгууллагуудын 2022 оны 7,8,9,10 дугаар сарын статистик тоон мэдээлэл дээр үндэслэн хяналт тавьж санхүүжүүлэх;
- Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал;

Байгууллагын дотоод хяналтын талаар

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын дагуу Эрүүл мэндийн төвийн даргын 2020 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр А/04 тоот тушаалаар баталсан “Эрүүл мэндийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын 2.2-т “Дотоод хяналт шалгалтын зорилго нь: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, хоол хүнс, эм эмнэлгийн хэрэгсэл, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ” гэж үйл ажиллагааг нь тодорхойлсон.

Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт, төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хийх дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, хяналтаар илрүүлсэн зөрчил, дутагдлыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна гэж үзлээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэнтэй холбоотойгоор нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 55,712.6 мянган төгрөгөөр буюу 9.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,804.0	28,128.0	17,324.0
Авлага	52,431.0	25.2	(52,405.8)
Бараа материал	45,454.6	68,569.2	23,114.6
Үндсэн хөрөнгө	453,059.6	520,739.4	67,679.8
Нийт хөрөнгө	561,749.3	617,461.8	55,712.6
Өр төлбөр	17,549.0	-	(17,549.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	544,200.3	617,461.8	73,261.6
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	561,749.3	617,461.8	55,712.6

Дээх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, бараа материал, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, бараа үйлчилгээний зардлын өглөг өссөн үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 17,324.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн даатгалын сангаас хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 52,405.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагыг барагдуулснаас нөлөөлсөн байна.
3. Бараа материал өмнөх оноос 23,114.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 36,844.2 мянган төгрөгийн тусгай зориулалттай материал, эм боох материал /Вакцин/-ыг Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй хүлээлгэн өгсөн нь гол нөлөө үзүүлсэн байна.
4. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 67,679.8 мянган төгрөгөөр нэмэгдэхэд Барилга, байгууламж 38,263.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Орон нутгийн хөгжлийн сангаас бариулж өгсөн эрүүл мэндийн төвийн дээврийн засвар, Эрүүл мэндийн сайдын 2022.12.07-ны өдрийн А581 тоот тушаалаар Яамнаас 59,198.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ирүүлсэн, Эрүүл мэндийн газрын 2022.09.07-ны А52 тоот тушаалаар 3,592.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж орлогод авсан зэрэг нь нөлөөлсөн байна.
5. Өглөг дансны үлдэгдэл 17,549.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өглөгийг барагдуулснаас нөлөөлсөн.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийгмийн даатгалын сангаас 476,031.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 22,909.2 мянган төгрөг, нийт зарлагыг 498,940.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 26,314.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд олгох шимтгэл 3,289.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 318.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардал 2,751.8 мянга төгрөг, нормативт зардал 38,269.4 мянга төгрөг, эд хогшил худалдан авах зардал 4,160.0 мянган төгрөг, томилолт, зочны зардал 1,239.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 2,119.0 мянган төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 2,408.7 мянган төгрөг, нийт 80,234.6 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна.

Энэ нь Баян сумын Эрүүл мэндийн төв нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйтэй холбоотой байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр эрүүл мэндийн даатгалын сангаас 394,328.4 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 24,377.2 мянган, нийт 418,705.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 436,737.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 19,392.7 мянган төгрөгийн санхүүжилт нийт 456,129.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 443,663.4 мянган төгрөг буюу 104.9 хувьтай байгаа нь хангамжийн материалын зардлыг 7,794.1 мянган, нормативт зардлыг 20,693.9 мянган, эд хогшил худалдан авах зардал 27,450.1 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 3,429.6

мянган төгрөгөөр тус тус хэтрүүлэн, цалингийн зардлыг 32,868.3 мянган, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 676.5 мянга, байр ашиглалтын зардлыг 4,984.5 мянга, албан томилолтын зардлыг 508.1 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг илүү зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээ 24,957.8 мянган төгрөгөөр илүү зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөг/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80302- нэг иргэнд ноогдох норматив	232,744.9	208,431.9	24,313.0	89.6
2	81603-үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	161,583.5	160,137.5	1,446.0	99.1
3	83603- Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	-	51,073.8	(51,073.8)	-
Дүн		394,328.4	419,643.2	(25,314.8)	106.4
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	24,377.2	24,020.2	357.0	98.5
Дүн		24,377.2	24,020.2	357.0	98.5
Нийт дүн		418,705.6	443,663.4	(24,957.8)	106.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 52,451.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Бараа үйлчилгээний бусад зардалд 52,451.0 төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сожидмаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 11/07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1.0 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Баян сумын эрүүл мэндийн төвийн 2022 оны батлагдсан төсвийн нийт зардлын 460,987.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,609.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг тогтооход тайлант оны батлагдсан төсөвт өөрчлөлт орсон тул нийт зардлын 1.0 хувиар буюу 4,187.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоов.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 20,330.3 мянган төгрөгийн зардлын хэтрэлт бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудагч ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 153 мэдээлэл байршуулахаас 150 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 удаагийн 260,781.8 мянган төгрөгийн орлого, 6 удаагийн 53,997.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын журналд байхгүй болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөг хүрэхгүй 16 удаагийн 26,720.4 мянган төгрөгийн орлогын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн "үнэн зөв" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын 4.2.1.10-г "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол;" гэж заасныг үндэслэн Албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Дотоод хяналтын үйл ажиллагаа нь зөвхөн эрүүл мэндийн үндсэн үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтын комисст санхүүгийн мэргэжлийн ажилтан ажиллуулах зөвлөмж өгөв.

2. Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: НБББББ-ийг стандарт, хууль, тогтоомж, тушаал, заавар, дүрэм журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, баталж мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

3. Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 3 иргэн, байгууллагын 4,004.6 мянган төгрөгөөр илүү байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлд төлбөрийн цахим баримтгүй ажил гүйлгээ бүртгэхгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймаг дахь Төрийн аудитын газартай 2022 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн ТӨА/2022/03 тоот санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх гэрээ байгуулснаас шалтгаалан завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 100,280.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, өгөгдсөнийг 63.4 хувь хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	100,280.8	1	63,588.3	63.4
Нийт дүн	1	100,280.8	1	63,588.3	63.4

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар худалдан авах ажиллагааны хэрэгжилт, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 214.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс, аудитын явцад 214.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

Үүнд:

1. Тайлант оны 1-4 саруудад хөгжлийн бэрхшээлтэй нэг ажилтны хөдөлмөрийн хөлснөөс хувь хүний орлогын албан татвар болох 214.0 мянган төгрөг суутгасныг;

2. Санхүүгийн тайланд төсвийн гүйцэтгэлийн тайлан, төсвийн тохируулгын тайланг бэлтгээгүйг тус тус Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасныг үндэслэн санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар нийт 5,186.0 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 268.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 4,917.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Цалин хөлсний талаар

Илрүүлэлт:

1. Нийт 19 ажилтанд олгосон мөнгөн урамшууллаас 268.7 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу тооцсон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-т "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:", 25.5-т "Суутган төлөгч нь албан татвар төлөгчид энэ хуулийн 23.1-д заасан хөнгөлөлтийг эдлүүлэхдээ тус хэсэгт заасан албан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, сар бүр эдлүүлнэ." гэж заасныг тус тус зөрчиж санхүүгийн тайлагналын үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" гэж заасныг үндэслэн Төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Цалин хөлстэй холбоотой асуудал:

Илрүүлэлт:

Анхан шатны баримтгүйгээр 4,917.3 мянган төгрөгийн нэмэгдлийг цалингийн зардлаар бүртгэсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.1-т "Аж ахуйн нэгж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна." батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн Албан шаардлага хүргүүлэв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант оны 1-4 саруудад хөгжлийн бэрхшээлтэй нэг ажилтны хөдөлмөрийн хөлснөөс хувь хүний орлогын албан татвар болох 214.0 мянган төгрөгийг суутгасан байна.	1	214.0	-	-	1	214.0	1	214.0	-	-	-	-
Дүн	1	214.0	-	-	1	214.0	1	214.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны баримтгүйгээр 4,917.3 мянган төгрөгийн нэмэгдлийг цалингийн зардлаар бүртгэсэн байна.	1	4,917.3	-	-	1	4,917.3	-	-	-	-	-	-
Нийт 19 ажилтанд олгосон мөнгөн урамшууллаас 268.7 мянган төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг дутуу тооцсон байна.	1	268.7	1	268.7	-	-	-	-	-	-	-	-
Дүн	2	5,186.0	1	268.7	1	4,917.3	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 153 мэдээлэл байршуулахаас 150 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээллийг байршуулаагүй, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 14 удаагийн 260,781.8 мянган төгрөгийн орлого, 6 удаагийн 53,997.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын журналд байхгүй болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөг хүрэхгүй 16 удаагийн 26,720.4 мянган төгрөгийн орлогын гүйлгээг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.	1	341,499.7	-	-	1	341,499.7	-	-
Дүн	1	341,499.7	-	-	1	341,499.7	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
2022 онд хийгдсэн дотоод аудитын үйл ажиллагаа нь зөвхөн сургалтын үйл ажиллагаанд чиглэгдсэн, санхүү, шилэн данс, нягтлан бодох бүртгэл, төсвийн тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай, төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт хийдэггүй, санхүүгийн мэргэжлийн ажилтан дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд томилогдоогүй, ажилтнууд нь дотоод хяналтын талаар сургалтад хамрагдаагүй, дотоод хяналтын талаар зохих мэдлэг эзэмшээгүй, дотоод хяналтын ажиллах журамгүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Байгууллагын мөрдөж буй НБББББ-нь шинэчлэн батлагдсан УСНББОУС, хууль, тогтоол, тушаал заавруудыг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 3 иргэн, байгууллагын 4,004.6 мянган төгрөгөөр илүү байна.	1	4,004.6	-	-	-	-	1	4,004.6
Дүн	3	4,004.6	-	-	-	-	3	4,004.6
Нийт дүн	4	345,504.3	-	-	1	341,499.7	3	4,004.6